

**“ХАЛХЫН ҮЙСЭН ЦААЗ” ДАХЬ НОЁДЫН УДАМ УГСААГ
ТОДРУУЛАХ АСУУДАЛД**

Э.ЖИГМЭДДОРЖ

Товч агуулга: “Халхын үйсэн цааз”-ын мэдээ нь XVI-XVII зууны Монголын язгууртан ноёд, тайж нарын удам угсааг улируулан шинжлэх тулгуур сурвалжийн нэг юм. Энэ өгүүлэлд “Модон барс жилийн намрын цааз”(1614)-ыг хэлэлцэн тогтоосон ноёдын угсаа язгуурыг тодруулах асуудалд анхаарал хандуулж, эдгээр язгууртнууд Гэрсэнз жалайр хун тайжийн 3, 4-р хөвгүүний удмын ноёд, тайж нар гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Өнөөгийн судалгааны түвшинд Халхын үйсэн цаазыг хэлэлцсэн язгууртнуудын угсаа гарвалын талаар судлаачдын дунд харилцан санал зөрүүтэй байгаа хэдий ч цаашид цаазын сэргээн засварласан эхийг нарийвчлан судалж, БНХАУ болон бусад улс оронд шинээр хэвлэгдэн гарч буй архивын баримт бичиг зэрэг эх хэрэглэгдэхүүнтэй харьцуулан үзсэнээр уг асуудлыг тодруулах бололцоотой хэмээн үзэж байна.

Түлхүүр үг: Халхын үйсэн цааз, тулгуур сурвалж, язгууртан, ноёд, тайж нар, удам угсаа

1. “Халхын үйсэн цааз” ба ноёдын угсаа гарал

Монгол улсын Булган аймгийн Дашинчилэн сумын нутаг дахь Хар бухын балгаснаас 1970 онд Монголын түүхч, археологич Х.Пэрлээ, Оросын эрдэмтэн Е.В.Шавкунов нарын удирдсан хээрийн судалгааны анги нээн илрүүлсэн 1400 гаруй үйсэн бичиг нь Төв Азийн түүх, соёл, буддын шашин, хууль цаазын үнэт дурсгал юм.

Х.Пэрлээ энэхүү дурсгалын дотроос үйсэн дээр бичсэн хууль цаазын хэсгийг судлан, монгол бичгийн гар хуулбар, латин үсгийн галиг, зарим тайлбарын хамт “Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн дурсгалт бичиг”¹ нэрээр 1974 онд Улаанбаатар хотноо хэвлүүлсэн нь судлаачдын анхаарлыг татсаар байна.

¹ Пэрлээ, Х. *Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн дурсгалт бичиг*. Тэргүүн дэвтэр. Монгол ба Төв Азийн орнуудын соёлын түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг. MONUMENTA HISTORICA. Tom. VI. Fasc.1.УБ., 1974.т.5-139 (хойшид “Халхын үйсэн цааз” хэмээн товчилно)

Энэ өгүүлэлд “Модон барс жилийн намрын цааз”(1614)-ыг хэлэлцэн тогтоосон язгууртан ноёдын удам угсааг тодруулах асуудалд анхаарал хандуулахыг зорьсон юм. Эдгээр ноёд, тайж нарын удам угсааг тодруулахдаа “Халхын үйсэн цааз” болон XVII зууны Халхын ноёдын айлтгал бичиг, Монголын он дарааллын бичиг, Манжийн “албан түүх” зэрэг сурвалжийн мэдээг харьцуулан нягталсан болно.

Хар бухын балгасны тууриас олдсон 1400 гаруй үйсэн бичгийн дурсгалыг 1990-ээд оноос Бонн их сургууль (Bonn University)-ийн профессор Клаус Загастер (Klaus Sagaster)-ын хүчин зүтгэлээр ХБНГУ-д сэргээн засварлаж, 2012 онд Монгол улсын Үндэсний номын санд хүлээлгэн өгсөн байна.

“Халхын үйсэн цааз”-ын агуулга нь XVI зууны сүүлчээс (1596) XVII зууны 30-аад он (1639) хүртэл Халхын язгууртан ноёдын 18 удаагийн чуулганаар хэлэлцэн тогтоосон цааз болон Чингисийн 9 өрлөгийн магтаалын шүлэг гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ¹.

“Халхын үйсэн цааз” нь хус модны үйсний өнгөн талыг хуулан цэвэрлэж, хуудасны ар болон өвөр талд уйгуржин монгол бичгээр хар бэхээр бичиж, ном хэлбэртэй дэвтэрлэн үдсэн, 10x14 см хэмжээтэй, нэг нүүрэнд 4-8 мөрөөр бичжээ.

Өнөөг хүртэл “Халхын үйсэн цааз”-ын эх бичиг, гэрэл зураг (facsimile) хэвлэгдээгүй учир судлаачид Х.Пэрлээгийн хэвлүүлсэн гар хуулбарыг баримтлан судалгаа хийж, бүтээлдээ ашигласаар иржээ.

Х.Пэрлээ “Халхын үйсэн цааз”-ыг анх судалгааны эргэлтэнд оруулж, 18 удаагийн чуулганаар цаазыг хэлэлцэн тогтоосон он цаг, газар, ноёдын угсаа гарал, цаазад гарч буй үг хэллэгийн тайлбар зэргийг хийсэн нь хойшдын судалгаанд чухал нөлөө үзүүлсэн юм.

Фүтаки Хироши (Futaki Hiroshi) бээр Х.Пэрлээгийн хэвлүүлсэн үйсэн цаазын монгол бичгийн гар хуулбарыг япон хэлнээ орчуулан зарим тайлбарын хамт “Үйсэн цаазын орчуулга, тайлбар” болон “Үйсэн цаазын тухай”² хэмээх өгүүлэл хэвлүүлсэн юм. Тэрээр үйсэн цаазыг японы судлаачдын хүртээл болгож, зарим цаазыг хэлэлцэн тогтоосон он цаг, ноёдын угсаа язгуурын талаар өөрийн санал дүгнэлтийг хийсэн байдаг.

¹ Энэ талаар дараах өгүүлээс дэлгэрүүлэн үзнэ үү. - Жигмэддорж, Э. “Халхын үйсэн цааз” дахь Чингис хааны 9 өрлөгийн магтаал. *Eurasian Nomadic Pastoralism: History, Culture, Environment. CNEAS Report 22*. Center for Northeast Asian Studies, Tohoku University. Sendai, 2016, 27-47

² 二木博史著「訳注白樺法典(I)」『遊牧社会史探究』第49期、1976年、pp.10-19 (Futaki Hiroshi. Үйсэн цаазын орчуулга тайлбар-I); 二木博史著「訳注白樺法典(II)」『モンゴル研究』第12期、1981年、50-63 (Futaki Hiroshi. Үйсэн цаазын орчуулга тайлбар-II); 二木博史著「白樺法典について」、『アジア アフリカ言語文化研究』第21期、1981年、49-73 (Futaki Hiroshi. Үйсэн цаазын тухай); 二木博史著「訳注白樺法典(III)」『モンゴル研究』第14期、1983年、12-27 (Futaki Hiroshi. Үйсэн цаазын орчуулга тайлбар-III).

А.Д.Насилов Халхын үйсэн цаазыг орос хэлээр орчуулан, монгол бичгийн текст, латин үсгийн галиг, хүн, газар ус, нэр томъёоны зарим тайлбарын хамт “Восемнадцать степных заканов памятник монгольского права XVI-XVII вв”¹ нэрээр хэвлүүлжээ. Тэрбээр зарим үг үсгийг орхиж, Х.Пэрлээгийн латин үсгийн галигт буй алдааг давтжээ.

Өмнөх судалгаанаас харахад Халхын үйсэн цаазыг хэлэлцэн тогтоосон язгууртан ноёдын угсаа гарлын тухай асуудал судлаачдын дунд харилцан санал зөрүүтэй хэвээр байна.

2.Цааз хэлэлцсэн ноёдын удам угсааг тодруулах асуудалд

XVI-XVII зууны Халхын үйсэн цааз нь тухайн цагийн язгууртан ноёдын намтар, үйл ажиллагааг улируулан шинжлэх тулгуур сурвалжийн нэг юм.

“Халхын үйсэн цааз” дахь ноёдын угсаа язгуур, нэр, цол зэргийг улируулан судлахад “Модон барс жилийн намрын цааз”(1614) чухал нөлөөтэй. Тус цаазын оршилд цааз хэлэлцэгч Халхын 24 язгууртны нэр, цолыг жагсаан бичсэн нь ноёдын угсаа гарлыг бусад сурвалжтай харьцуулан судлах боломжийг олгож байна.

Халхын үйсэн цааз, 1640 оны “Их цааз”, “Гэгээн Сэцэн хан хөвгүүддээ өмч хуваасан тэмдэглэл” зэрэг сурвалжид цааз хэлэлцэгч ноёд болон өмч хүртсэн язгууртныг жагсаан тэмдэглэхдээ тэдний угсаа язгуур, насны эрэмбэ дарааг харгалзан бичсэн зүйл ажиглагдаж буйгаас үзвэл энэ нь тухайн цагийн монголчуудын бичгийн тогтсон ёс байсан бололтой.

Халхын үйсэн цаазыг хэлэлцэн тогтоосон язгууртан ноёд, тайж нарын нэр, цол болон нэрсийн дэс дараалал нь тэдний удам угсааг тодруулах гол баримжаа болно. Үйсэн цаазад язгууртан ноён, тайж нарыг нэрээр, цолоор, эсвэл нэр, цолыг хамтатган бичсэн гурван янзын бичлэг байна. Үйсэн цаазад ноёдын нэрийг ямар дэс дарааллаар бичсэнийг нягталсанаар язгууртны угсаа гарлыг тодруулах бололцоотой.

¹ *Восемнадцать степных заканов памятник монгольского права XVI-XVII вв.* Монгольской текст, транслитерация монгольского текста. Перевод с монгольского комментарий и исследование А.Д.Насилова. Санкт-Петербург: 2002. Жич, А.Д.Насилов бээр үүнээс гадна үйсэн цаазын талаар хэвлүүлсэн хэд хэдэн өгүүллийн нэрийг ном зүйдээ дурьдсан бөгөөд бид харамсалтай нь хараахан олж үзээгүй байна. Үзнэ үү. Насилов А.Д. “Восемнадцать степных заканов” источник по истории Халхи XVIII. *Тез. Конф. Аспирантов и молодых науч. сотрудников ИВ АН СССР*. Т.И. Москва: 1983; Насилов А.Д. К вопросу о положении Халха Монголии в XVII в. *Древний и средневековый Восток: История, филология. Проблемы источниковедения*. Москва: 1984; Насилов А.Д. Новые сведения о монгольском феодальном праве. *Mongolica: Памяти акад. Б.Я.Владимирцова*. Москва: 1986

Арга зүйн хувьд цааз бичгийн энэхүү онцлог байдлыг харгалзан, бусад сурвалжид ноёдын нэр, цолыг хэрхэн бичсэнтэй харьцуулан үзэх замаар “Модон барс жилийн намрын цааз”-ыг хэлэлцэн тогтоосон ноёдын угсаа язгуурыг тодруулахыг оролдсон юм.

“Модон барс жилийн намрын цааз”-ын оршилд цааз хэлэлцэгч ноёд, тайж нарын нэрийг бичсэн байдлыг сийрүүлбэл,

“om suwasti siddam, modun bars jil-ün namur-un ečüs sara-yin nigen sinede altaγad-un γool deger-e tüsiye-tü qaγan, köndelen čökür noyan, dayičing qung tayiji, dalai sečen qung tayiji, čoγ-tu qung tayiji, sečen tayiji, čaγan tayiji, erdeni tayiji, duraγal tayiji, loyaγ tayiji, nom-či tayiji, erke tayiji, mačari tayiji, labari tayiji, čabari tayiji, qolači tayiji, baγatur tayiji, joriγ-tu tayiji, čolum tayiji, noyan tayiji, baba tayiji, bing-tü tayiji, günbü-skib tayiji, čembüm tayiji edün bügüde noyad-i čaγaγa nigedbe...”¹

хэмээжээ.

“Модон барс жилийн намрын цааз”-ын оршилд язгууртны нэрсийг дараалуулан бичихдээ тэдний угсаа язгуур, насны эрэмбэ дарааг баримтлан салааны тэргүүлэх ноёд буюу Оноху үйзэн ноёны ахмад хөвгүүн Абтайн удмын Түшээт хан, дөтгөөр хөвгүүн Түмэнхэн хүндлэн цөхүр, хоёрдугаар хөвгүүн Абуху мэргэн ноёны ахмад хөвгүүн Дайчин хун тайж, Амин дурал ноёны ач хүү Далай сэцэн хун тайж, Оноху үйзэн ноёны тавдугаар хөвгүүн Бахарай хошуучийн ахмад хөвгүүн Цогт хун тайж зэрэг ноёдыг тэргүүнд бичиж үүний араас бусад тайж, ноёдыг жагсаажээ.

“Модон барс жилийн намрын цааз”-д бичигдсэн ноёдын угсаа гарлыг “Асрагч нэртийн түүх”, “Шар тууж” зэрэг түүхэн эх сурвалжид тулгуурлан барагцаалан гаргавал үе ойролцоо, төрлийн тайж нар болох нь мэдэгдэж байна. Үүнд:

- | | |
|----------------------------|---|
| 1. tüsiye-tü qaγan | - Абтай ханы ач хүү Гүмбү Түшээт хан |
| 2. köndelen čökür noyan | - Охунуху үйзэн ноёны дөтгөөр хөвгүүн |
| 3. dayičing qung tayij | - Абуху мэргэн ноёны ахмад хөвгүүн |
| 4. dalai sečen qung tayiji | - Амин дурал ноёны ач хүү Шолой Сэцэн хан |
| 5. čoγ-tu qung tayiji | - Бахарай хошууч ноёны гагц хүү |
| 6. sečen tayiji | - Түмэнхэн хөндлөн цөхүрийн ахмад хөвгүүн |
| 7. čaγan tayiji | - (?) |
| 8. erdeni tayiji | - Түмэнхэн хөндлөн цөхүрийн дэд хөвгүүн (?) |
| 9. duraγal tayiji | - Түмэнхэн хөндлөн цөхүрийн гутгаар хөвгүүн |

¹ Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, 42

- | | |
|------------------------|---|
| 10. loyaγ tayiji | - Түмэнхэн хөндлөн цөхүрийн дөтгөөр хөвгүүн |
| 11. nom-či tayji | - (?) |
| 12. erke tayiji | - (?) |
| 13. mačari tayiji | - Шолой сэцэн ханы ахмад хөвгүүн |
| 14. labari tayiji | - Шолой сэцэн ханы дэд хөвгүүн |
| 15. čabari tayiji | - Шолой сэцэн ханы гутгаар хөвгүүн |
| 16. qolači tayiji | - Шолой убашаи хун тайжийн хүү Умаху холч (?) |
| 17. baγatur tayiji | - (?) |
| 18. joriγ-tu tayiji | - (?) |
| 19. čolum tayiji | - Жодба сэцэний ахмад хөвгүүн |
| 20. noyan tayiji | - (?) |
| 21. baba tayiji | - Шолой сэцэн ханы дөтгөөр хөвгүүн |
| 22. bing-tü tayiji | - Ангаахай мэргэн ноён гутгаар хөвгүүн |
| 23. günbü-skiba tayiji | - Рахул далай ноёны дэд хөвгүүн |
| 24. čembüm tayiji | - (?) |

нар болно.

“Модон барс жилийн намрын цааз”-ыг хэлэлцэн тогтоосон зарим ноёд, тайж нарын угсаа гарлын асуудлыг тодруулан авч үзье.

tüsiye-tü qaγan (*Түшээт хан*): “Модон барс жилийн намрын цааз”-ыг хэлэлцсэн язгууртны тэргүүнд Түшээт хан бичигджээ. Энэ Түшээт хаан бол Гэрсэнз жалайр хун тайжийн гутгаар хөвгүүн Оноху үйзэн ноёны ахмад хөвгүүн Абтай сайн хааны хоёрдугаар хөвгүүн Эрээхэй (eriyekei) мэргэн ноёны ахмад хөвгүүн бөгөөд нэр Гомбо (gümbü) түшээт хаан¹ юм.

Эдүгээ бидэнд мэдэгдэж буй баримтаар Гомбо түшээт хаан анх Манжтай харилцсан нь Сэцэн хааны 9-р (1635) онд холбогдоно. Хуучин манж бичгийн дансны Сэцэн хааны 9-р оны 5 сарын 27-ны өдрийн бичигт:

“oom suvasti siddam sayin amuyulang boltuγai, / maq-a samadi sečen qaγan, tusiyetü qaγan, sečen jinung ekilen yeke baγa noyad, / usun-u jiran γurban omuytan-u ejen boluγsan sečen qaγan-du bičig örgün bariba...”²

гэжээ.

“XVII зууны эхэн хагаст холбогдох монгол үсгийн бичиг дэвтэр”, “Монгол данс эвхмэлийн эмхтгэл”, “Дайчин улсын магад хууль”, “Зарлигаар Тогтоосон Гадаад Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир”³ зэрэг сурвалжийн

¹ byamba-yin Asarayči neretü(-yin) teüke, 77

² 『満文原檔』第九冊、国立故宫博物館、2005年、4291 (Хуучин манж данс)

³ *Зарлигаар Тогтоосон Гадаад Монгол, Хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир* (хойшид)

мэдээнээс харахад Түшээт хаан Манжтай идэвхтэй харилцаж, Манжийн хаад ч мөн хариу элч зарж, бичиг илгээжээ. Түүнчлэн XVII зууны Түвдийн түүхийг судалсан Zahiruddin Ahmad “Sino-Tibetan relations in the seventeenth century”¹ бүтээлд дурьдсанаар Халхын ноёдын дотроос Гомбо түшээт хан Далай ламтай идэвхтэй харилцаж байжээ.

1640 оны Халх-Ойрадын “Их цааз”²-ын оршилд Буддын шашны хувилгаадын нэр болон цааз тогтоосон хугацаа, хэлэлцэгч ноёдыг дараах байдлаар дэс дараалуулан бичсэн байна. Үүнд,

“...šakiy-e-yin toyin ečiḡe inčīn rimbuči kiged angki kubi manjuširi, amuba sisi manjuširi yurban qutuγtu-yin gegen-ü emün-e bayatur temür luu kemekü jil-un namur-un dumdadu sar-a-yin tabun sine-dü sayin edür-tü, erdeni jasaγtu qan ekilen tüsiyetü qan ubasi dalai noyan ...”³

хэмээн эхэлсэн уг цаазад Халх, Ойрад, Хошууд, Хөх нуурын ноёд, Ижил мөрний Торгуудын төлөөлөгчид бүгд 28 язгууртны нэр дурьдагдсанаас Эрдэнэ Засагт хаан тэргүүнд, Түшээт хаан хоёрдугаарт бичигджээ. Засагт хаан угсаа гарвалын талаас Гэрсэнз жалайр хун тайжийн ахмад хөвгүүний удам, нас ахмад болохын хувьд цаазыг хэлэлцэхэд тэргүүлэх байранд бичигдсэн бололтой.

“Монгол данс эвхмэлийн эмхтгэл”-д хэвлэгдсэн Халхын зүүн гараас Манжид илгээсэн бичиг болон Манж хаанаас хариу ирүүлсэн бичгүүдэд Түшээт хааны нэр хэддүгээрт бичигдсэнийг жишээ татвал,

- Эээр засагчийн 5-р (1648) оны сайн өдөр Халхын зүүн гарын ноёдоос Баарины тэмээ адууг буцаасан айлтгал бичигт:

“oom suwasti siddam, / qayan-u gegen-e, qoyar qayan nom-un ejen bičig ergü-be...”⁴

гэжээ. Уг айлтгалд “хааны гэгээнээ” хэмээх нь Манжийн Эээр засагч хаан, харин хоёр хаан гэсэн нь Түшээт хаан, Сэцэн хаан нарыг хэлж буй бололтой.

- Эээр засагчийн 7-р /1650/ оны 10 сарын 25-нд Халхын ноёдоос Эээр засагч хаанд эе зохицлын тул өргөсөн бичигт:

“Илтгэл шастир” хэмээн товчилно)

¹ Zahiruddin Ahmad. *Sino-Tibetan relations in the Seventeenth century*. Roma: 1970, 152-162

² 1640 оны цаазыг судлаачдын бүтээлд “Монгол-Ойрадын цааз”, “Халх-Ойрадын цааз”, “Ойрад цааз”, “Их цааз” гэх мэт янз бүрээр нэрлэж бичдэг. Судлаач Б.Баярсайхан уг цаазыг 1640 оны “Их цааз” гэж нэрлэх нь зүйтэй хэмээсэнд бид тал өгч байна. Үзнэ үү. Баярсайхан, Б. “Монголын хууль цаазын эх сурвалжийн нэрийн тухайд”, *Эрх зүй*. 2-3/ 2007(16-17), 2007, 154

³ mongγol oyirad-un šaγaγ-yin bičig. n.buyanöljei, bao ge qaričaγulun tayilburilaba. öbür mongγol-un arad-un keblel-ün qoriγ-a, 2000, 2-3

⁴ mongγol dangsa ebkemel-ün emkidkel. γurbaduγar emkidkel. 2003, 15

“oom suwasti siddam, / qayan-u gegen-e, qayan nom-un ejen ekilen bügüde noyad bičig ergübe...”¹ хэмээжээ.

Энд гарч буй “хаан” хэмээх нь Түшээт хаан, “номын эзэн” нь Данзан лам, харин “бүгд ноёд” бол нийт Халхын ноёдыг бус Халхын зүүн гарын язгууртныг хэлжээ.

Манжийн хаанаас Халхад илгээсэн бичигт ноёдын нэрийг дэс дараалуулсан байдлыг үзвэл, Эээр засагчын 7-р (1650) оны өвлийн дундад сарын шинийн 22-нд Эээр засагч хаанаас Халхын ноёдыг жил бүр есөн цагааны алба хүргэгтүн хэмээн шаардсан зарлигт:

“qayan-u jarliу bičig, jasaу-tu qayan, tüsiyetü qayan, sdanjin lam-a, ombu erdeni kedün yeke baу-a noyad-tur baуulуabai ...”²

гэсэн буй. Уг зарлигт Гэрсэнз жалайр хун тайжийн ахмад хөвгүүн Ашихайн удам Засагт хааныг тэргүүнд, дараагаар Гэрсэнзийн гутгаар хөвгүүн Оноху үйзэн ноёны ахмад хөвгүүн Түшээт хаан, Гэрсэнзийн дөтгөөр хөвгүүн Түмэнхэн хүндлэн цөхүрийн хоёрдугаар хөвгүүн Данзан лам гэх зэргээр ноёдыг угсаа гарал, насны эрэмбэ дарааллын дагуу жагаасан бөгөөд эдгээр ноёдыг “тэндэх тэргүүлэгч” хэмээн бичсэн байна.

Түшээт хааны Халх дахь байр суурыг судлаачид өвөг Абтай сайн хааны шашин, улс төрийн үйл ажиллагааны үр хөврөл хэмээн үздэг. Энэ тухайд Д.Гонгор өөрийн бүтээлдээ “Абтайн шашны арга явууллага нь Халх, Ойрадыг зонхилон мэдэх улс төрийн бодлогоос үүдэж гарсан бөгөөд түүний үр хөвгүүдийн үед үр дагавар нь тодорхой болжээ”³ хэмээсэн бол Жагачидай Буяндэлгэр 1680-аад онд Халхын хаад, ноёдоос Манжийн Энх-Амгалан хаанд өгсөн айлтгал бичгийг судалсны дүнд “...Түшээт хаан Гомбодорж, Чахундорж нар өөрийн дээдэс Абтай хааны тавьсан нийт Халхын эзэн хааны байр суурийг XVII зууны сүүлч болтол хадгалсаар байсан...”⁴ гэж үзжээ.

“Монгол данс эвхмэлийн эмхтгэл”-д нийтлэгдсэн дээрх бичгүүдээс харахад, Гомбо Түшээт хаан Манжтай идэвхтэй харилцаж байсан бөгөөд Халхын зүүн гарын ноёдын дотор тэргүүлэх байр суурьтай байжээ.

¹ mongyol dangsa ebkemel-ün emkidkel. yurbaduуar emkidkel. 2003, 165

² mongyol dangsa ebkemel-ün emkidkel. yurbaduуar emkidkel. 2003, 172-177

³ Гонгор, Д. Халх товчоон-I. Улаанбаатар: 1970, 195

⁴ jiyaciдай buyandelger. abatai qayan ba tümed-ün altan qayan-u qaričayan-ača qalq-a-yin erten-ü teüken deki kedün asayudal-i sedüblekü inü, öbür mongyol-un yeke surγayüli-yin erdem sinjilgen-ü setkül. 1999 он-у I düger quууčaу-a, 90

köndelen čökür noyan (*Хөндлөн цөхүр ноён*): Тэрбээр “Модон барс жилийн намрын цааз”-ыг хэлэлцсэн ноёдын хоёрдугаар бичигдсэн бөгөөд хожмын Халхын Сайн ноён аймгийн дээд өвөг юм. “Илтгэл шаштир” болон Эрдэнэ зуу, Өндөр гэгээний намтар зэрэг сурвалжид тэмдэглэснээр Түмэнхэн хөндлөн цөхүр ах Абгайн адилаар шарын шашныг тэтгэн дэлгэрүүлэх үйлсэд хүчин зүтгэж Далай ламаас “Сайн ноён” цол хүртжээ. Энэ тухай “Илтгэл шаштир”-ын 69-р дэвтэр, “Халхын сайн ноён аймгийн шастирын хураангуй”-д:

“tuγtam qalq-a-dur / ulayan šasin kemegsen anu bui, šir-a šasin-u / kümün-lüge temčeldüküi-dür, түмөнгөкөн šir-a šasin-i / degedülejü, qamaγalan qarγaljaγsan-u tulada, tangγud-un / dalai blam-a tegün-i sayisiyaγu, sayin noyan čola / soyurqaju, qariyatu ayimaγ-un arad-i, čöm γurban / qan-luγ-a adali tegün-i күндүлегүлкү бүлүге...”¹ гэжээ.

“Илтгэл шаштир”-ын энэ мэдээг Lan Mei Hua “...1622 онд өргөгдөн асрагдсан тавдугаар төрлийн далай лам Лувсанжамцаас Түмэнхэний гэлэгбад туслан Түвдэд хүрсэн гавьяа зүтгэлийг нотлон соёрхсон явдлыг зааж байгаа нь лавтай”² гэж үзсэн бөгөөд чухам ямар сурвалжид тулгуурлан уг үндэслэлийг дэвшүүлсэнээ дурьдсангүй.

Түмэнхэн хөндлөн цөхүр шарын шашны өглөгийн эзэн болж, Далай ламаас цол хүртсэнээр тухайн үеийн Халхын нийгэмд түүний нэр нөлөө дээшилж, улмаар залгамжлагчид нь Түвдтэй харилцаатай байж, Халхын зүүн гарын язгууртны дотор нөлөө бүхий байр эзлэх үндсийг тавьсан бололтой.

Цөхүр ноёны залгамжлагчдаас гутгаар хөвгүүн Эрдэнэ үйзэн ноён тойн болсоны хойно Данжин лам хэмээн нэрлэгдэж, мөнхүү Далай ламаас “Номын хан” цол соёрхогджээ. Энэ тухай “Илтгэл шаштир”-т:

“...tümengken / ügei boluγsan-u qoyin-a, tegün-ü qoyaduγar köbegün / danjin lam-a-yi, dalai blam-a basa nom-un qaγan / kemen čola soyurqabai”³

хэмээжээ.

“Халхын үйсэн цааз”-д Түмэнхэн хүндлэн цөхүр ноёны хөвгүүдээс ахмад хөвгүүн Жодба сэцэний⁴ нэр бичигдсэн ба 1640 оны “Их цааз” болон XVII зууны

¹ ilekkel šastir-un jiran yusüdüger debter, šastir-un tabin γurbaduγar, qalq-a-yin sayin noyan ayimaγ-un šastir-un quriyangγui, 4 b.

² pan mei hua. tümengken-ü ger törül bolun sayin noyan ayimaγ-un bayiyulaγdayсан, öbür mongγol-un yeke surγayüli-yin erdem sinjilgen-ü setkül. 1999 on-u 2 duγar quγuцаγ-a, 52

³ ilekkel šastir-un jiran yisüdüger debter, šastir-un tabin γurbaduγar, qalq-a-yin sayin noyan ayimaγ-un šastir-un quriyangγui, 4 b.

⁴ Эр модон жилийн Сайхны сүмийн цааз /1614/-д тэрбээр jodba сецен тауји (Жодба сэцэн тайж) хэмээн тэмдэглэгджээ. - Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, 39

дунд үеийн Халх-Манжийн харилцааны бичигт түүний нэр огт гарахгүй тэрбээр нэгэнт нас барсан бололтой. Иймд Данзан лам Түмэнхэний хоёрдугаар хөвгүүний хувьд төрлийн тайж нарын дотор тэргүүлэх байр суурьтай болжээ.

dayicing qung tayij (*Дайчин хун тайж*): “Модон барс жилийн намрын цааз”-ыг хэлэлцэн тогтоосон dayicing qung tayij нь Абуху мэргэн ноёны ахмад хөвгүүн.

dalai sečen qung tayiji (*Далай Сэцэн хун тайж*): Далай Сэцэн хун тайж (dalai sečen qung tayiji) хэмээх нь Амин дурал ноёны ач хүү Халхын Шолой Сэцэн хан.

šoγ-tu qung tayiji (*Цогт хун тайж*): Цогт хун тайж (šoγ-tu qung tayiji) нь Абатай хааны дүү Бахарай хошууч ноёны ганц хүү гэдэг нь “Асрагт нэртийн түүх” болон “Шар тууж”-ийн мэдээгээр эргэлзээгүй байна.

sečen tayiji (*Сэцэн тайж*): “Модон барс жилийн намрын цааз”-д гарч буй Сэцэн тайжийг Х.Пэрлээ Засагт хан аймгийн Жунду дай баатарын хүү Ангату сэцэн тайж мөн болов уу¹ хэмээн тайлбарласан бол Фүтаки Хироши түүнийг Түмэнхэн хөндлөн цөхүрийн ахмад хөвгүүн Жодба сэцэн мөн² гэж үзжээ.

“Асрагч нэртийн түүх” болон “Шар тууж”-ид Түмэнхэний ахмад хөвгүүнийг “Жодба сэцэн ноён” хэмээн бичжээ. “Илтгэл шастир”-ийн 72-р дэвтэр, шастирын 36-рт Жодба ноёныг cola sečen pouan kememUi³ гэсэн тэмдэглэл байгаа зэргээс үзэхэд, Сэцэн тайж нь Түмэнхэний ахмад хөвгүүн Жодба ноён мөн ажээ.

ᠰаγан тайiji (*Цаган тайж*): Энэ тайжийн угсаа гарлыг Х.Пэрлээ “Засагт хан аймгийн XVII зууны ноёдын дотор Төвд хатан баатарын ач хөвгүүн Цаганскиб сэцэн жонон буюу Сайн ахай дайчин хэмээх ноён байжээ. Бодвол тэр Цаган тайж мөн ажгуу”⁴ хэмээн тайлбарласан нь эргэлзээтэй санагдана. Учир нь уг цаазад гарах бусад ноёд угсаа гарлын хувьд Гэрсэнз жалайр хун тайжийн 3, 4, 6-р хөвгүүний удам буюу Түшээт хан, Сэцэн хан аймгийн язгууртнууд байгаа нь үүнийг дахин нягтлууштайг харуулж байна.

Түмэнхэн хөндлөн цөхүрийн хөвгүүд: “Модон барс жилийн намрын цааз”(1614)-ыг хэлэлцэхэд Халхын Сайн ноён аймгийн дээд өвөг Түмэнхэн хөндлөн цөхүрийн 3 хөвгүүн оролцжээ. “Асрагч нэртийн түүх”, “Шар тууж”-ийн мэдээг үндэслэвэл “Модон барс жилийн намрын цааз”(1614)-д нэр дурьдагдсан erdeni tayiji (Эрдэнэ тайж) нь Түмэнхэн хөндлөн цөхүрийн дэд хөвгүүн, duraγal tayiji (Дурагал тайж)

¹ Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, 121

² 二木博史著「訳注白樺法典(II)」、『モンゴル研究』第12期、1981年、p.56

³ iledkel šastir-un dalan qoyadyar debter, šastir-un tabin jiryudyar, jasyγ ulus-un tüsiy-e güng todū erdeni-yin oladburi-yin šastir. 1 a, b.

⁴ Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, 127

нь Түмэнхэн хөндлөн цөхүрийн гутгаар хөвгүүн, loyaу таујі (Лояаг тайж) нь Түмэнхэн хөндлөн цөхүрийн дөтгөөр хөвгүүн мөн хэмээн үзэж байна.

nom-či таујі (Номч тайж): Номч тайжийг Х.Пэрлээ “...*Лабдарын дэд хөвгүүн Номч хун тайж болов уу...*”¹ хэмээн таамагласан бол Фүтаки Хироши бээр Өлзийт хун тайжийн ууган хүү Орхудай номч байж магадгүй² гэжээ. Бидний үзэж байгаагаар тус цаазад ноёдыг угсаа язгуур, насны эрэмбэ дараагаар жагсаан бичсэнийг үндэслэвэл “Номч тайж” нь Өлзийт хун тайжийн ахмад Орхудай номч мөн байж болох талтай.

erke таујі (Эрх тайж): Энэ тайжийн уг гарлыг баттай тогтоож чадаагүй бөгөөд цаазад оролцсон язгууртнуудыг язгуур угсаа, насны эрэмбэ дараагаар бичсэн онцлогыг харгалзан үзвэл Түшээт хан, эсвэл Сэцэн хан төрлийн тайж байх боломжтой юм.

Сэцэн ханы хөвүүд: “Модон барс жилийн намрын цааз”(1614)-д Халхын Сэцэн хан Шолойн ахмад гурван маcari таујі (Мачари тайж), labari таујі (Лабари тайж), čabari таујі (Чабари тайж) нар оролцжээ.

Энэ дашрамд нэгэн зүйлийг тэмдэглэхэд Асрагч нэртийн түүх”, “Өмч хуваасан тэмдэглэл”, “Шар тууж” зэрэг сурвалжид Сэцэн хааныг 11 хөвгүүнтэй хэмээн бичсэн байх бөгөөд харин дэс дараалал ялгаатай байна. Түүхийн зохиолуудад язгууртны хөвгүүдийг дэслэн тэмдэглэхдээ насны эрэмбэ дарааг голлохоос гадна их, бага аль хатны хөвгүүн болохыг харгалзан бичсэн тохиолдол байдаг*³. Харин Махасамади хааны хөвгүүдийн тухайд “Асрагч нэртийн түүх” болон “Шар тууж”-д насны эрэмбээр бичсэн бололтой байдаг ба “Өмч хуваасан тэмдэглэл”-д чухам юуг баримталсан, “Илтгэл шастир”-ыг эмхэтгэгч ямар сурвалжид үндэслэсийг хараахан тодруулаагүй байна.

“Өмч хуваасан тэмдэглэл”-д Сэцэн хааны 11 хөвгүүний нэр цолыг “...*nigedüger köbegün mačikir ildeng ... qoyaduγar köbegün tangγud čebden qung tayiji ...*” гэх мэтээр дэс дараалуулан бичсэн ба үүнийг Халхын ноёдын угсаа залгамжлалыг тэмдэглэсэн “Асрагч нэртийн түүх”, “Шар тууж”, “Илтгэл шастир” зэрэг бусад сурвалжийн мэдээтэй харьцуулан үзье.

¹ Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, 127

² 二木博史著「訳注白樺法典(III)」、『モンゴル研究』第14期、1983年、22.

³ Дарма гүүшийн “Алтан хүрдэн мянган хигээст бичиг”-г Хорчины зарим ноёдын уг эхийг тэмдэглэхдээ их, бага аль хатнаас төрсөнийг баримтлан бичсэн байдаг. - altan kürdün mingran kegesütü bičig. Kopenhagen: 1958, 76

Хүснэгт. Сэцэн хааны хөвгүүдийн нэрийг сурвалжид тэмдэглэсэн нь

| д/д | Асрагч нэртийн түүх ²⁵⁷ | Шар тууж ²⁵⁸ | “Өмч хуваасан тэмдэглэл” | Илтгэл шастир ²⁵⁹ | |
|--------------|------------------------------------|--------------------------|----------------------------|------------------------------|---------------------------|
| | | | | нэр | цол |
| 1-р хөвгүүн | maġari yeldeng tüsiyetü | maġari yelden tüsiyetü | maċikir ildeng | maġari | yelden tüsiyetü |
| 2-р хөвгүүн | laburi erke tayiji | labari erke tayiji | tangyud ċebden qung tayiji | ċaburi | erdeni tayiji |
| 3-р хөвгүүн | ċabari erdeni ubasi | ċabari erdeni ubasi | ċaburi erdeni ubaši | laburi | erke tayiji |
| 4-р хөвгүүн | baba seċen qaġan | baba seċen qaġan | - ²⁶⁰ | bumba | baġatar darġan qun tayiji |
| 5-р хөвгүүн | bumba darġan qung tayiji | bumba darġan qung tayiji | babu | babu | seċen qan |
| 6-р хөвгүүн | ċosġib ubasi qung tayiji | ċoskib ubasi qung tayiji | ċoskib ubaši qungtayiji | ċoskib | erdeni qun tayiji |
| 7-р хөвгүүн | ananda erke qung tayiji | beyise dalai ġinung | bumba darġan qungtayiji | badamdasi | dalai qun tayiji |
| 8-р хөвгүүн | tangyud erdeni qung tayiji | beyise ċebden ġinung | sarandasi qatan baġatur | ċebden | seċen ġinung |
| 9-р хөвгүүн | sira brasi qatan baġatur | šira dasi qatan baġatur | ananda dalai ġinung | ananda | dalai ġinung |
| 10-р хөвгүүн | dalai qung tayiji | dalai qung tayiji | badmasi dalai qung tayiji | budaġab | erdeni ġinung |
| 11-р хөвгүүн | budaġab erke tayiji | beyise budaġab ġinung | budaġab erdeni ġinung | - | - |

Хүснэгтээс харахад “Асрагч нэртийн түүх”-нд Сэцэн хааны хөвгүүдийг ихэвчлэн язгуурын нэр цолоор тэмдэглэсэн бол Халх Манжид дагаар орсоноос хойшхи “Өмч хуваасан тэмдэглэл”, “Шар тууж” болон Манж Чин улсын албан түүхэнд Манжийн хаанаас хүртсэн цолыг бичжээ.

qolaċi tayiji (*Холачи тайж*): Х.Пэрлээ энэ тайжийг “...Шолой убаши хун тайжийн нэгэн хатнаас төрсөн Умаху холч ноён байжээ. Энэ мөн бусыг ялгаж эс чадав...”⁵ хэмээн тэмдэглэсэн ба Фүтаки Хироши үйсэн цаазад гарах lamadar tayiji болон qolaċi tayiji нь нэг хүн буюу Эрээхэй ханы гутгаар хөвгүүн Ламадар холч дархан хун тайж⁶ гэж үзжээ.

“Модон барс жилийн намрын цааз”-ын оршилд ноёдыг угсаа, насны эрэмбэ дарааг харгалзан бичсэнийг бодвол энэ Холч тайж нь Ламадар тайж биш бололтой

¹ byamba-yin Asaraġci neretü(-yin) teike, 2002, 86

² Шара туджи, 92

³ ileđkel šastir-un tabin ġurbaduġar debter, šastir-un ġuċin doluduġar, qalq-a-yin ċeċen qan ayimaġ-un šastir-un qurıyangyui, 2 a - 4 a.

⁴ 4-р хөвгүүний нэр бичигдээгүй

⁵ Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, 127

⁶ 二木博史著 「訳注白樺法典(III)」、『モンゴル研究』第14期、1983年、23

бөгөөд Шолой убаши хун тайжийн хүү Умаху холч мөн эсэхийг хэлэхэд бэрх байна.

baγatur tayiji (*Баатар тайж*): Түүнийг Х.Пэрлээ “Түшээт хаан Гомбодоржийн хоёрдугаар хөвгүүн баатар хун тайж...”¹ хэмээн тайлбарласан буй. “Модон барс жилийн намрын цааз”-ын Халхын Сэцэн ханы ахмад хөвгүүдийн нэр буй тул Түшээт хаан Гомбодоржийн ахмад хөвгүүн Баатар тайж буюу šidisiṛi (Шидшир) тус цаазыг хэлэлцсэн байх бүрэн боломжтой юм. Учир нь Түшээт хаан болон Сэцэн хааны хөвгүүд нь нэгэн үеийн тайж нар билээ.

joṗiγ-tu tayiji (*Зоригт тайж*): Энэ тайжийн угсаа гарлын тухайд Х.Пэрлээ “Монголын түүхийн бичиг зохиолд үзвээс, Увш хун тайжийн гутгаар хөвгүүн Зоригт тайж, Отгон Саму буймын хөвгүүн Хүнгор зоргал хааны гудгаар дүү Чандган сайн Мажиг зоригт, Бадам дайчин зоригт гал гахайтай (1587) хэмээн тус тус бичсэн байх тул ялган салгаж мэдэхүйе бэрх байна”² гэжээ.

Бидний бодоход “Модон барс жилийн намрын цааз”-ыг хэлэлцэхэд Шолой убаши хун тайжийн хөвгүүн Умаху холч оролцсон гэж үзвэл энэхүү Зоригт тайж нь Шолойн гутгаар хөвгүүн байх бололцоотой юм.

šolum tayiji (*Цолум тайж*): Х.Пэрлээ үйсэн цааз бичгийг судлан хэвлүүлсэн бүтээлдээ “Модон барс жилийн намрын цааз”(1614)-д гарах colum tayiji-ыг “Жодовын гурван өөр эхтэй арван хөвгүүний ахмад Чолум ...бололтой”³ хэмээн бичсэн ба Японы монголч эрдэмтэн Фүтаки Хироши өөрийн өгүүлэлдээ уг саналыг дэмжсэн байдаг⁴.

Бид энэхүү тайжийг Жодба сэцэн ноёны ахмад хүү Тарба цолум хошууч (tarba šolum qosiyuci) бололтой гэсэн саналыг дэмжиж байгаа болно. Учир нь “Асрагч нэргийн түүх”, “Шар тууж”-ид Жодба сэцэн ноёны 9 хөвгүүний ахмад нь Тарба цолум хошууч гэсэн байдаг.

Харин “Илтгэл шастир”-г түүний нэр тэмдэглэгдээгүй байна. Шастирт Жодба сэцэнийг Чиман (ciman), Цэсгив (českib) Соном хошууч (sonum qosiyuci) хэмээх гурван хөвгүүнтэй гэжээ⁵. Жодба сэцэн ноёны залгамжлагчдаас анх Соном хошуучийн хөвгүүн Тод эрдэнэ Энх-Амгалангийн 30-р оны (1691) Долон нуурын чуулганаар “Улсад туслагч гүн” өргөмжлөгджээ.

¹ Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, 128

² Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, 125

³ Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, 128

⁴ 二木博史著「訳注白樺法典(III)」、『モンゴル研究』第14期、1983年、東京。23

⁵ iledkel šastir-un dalan qoyaduγar debter, šastir-un tabin jiryuduγar, jaṣaγ ulus-un tüsiy-e güng todū erdeni-yin oladburi-yin šastir. 1 b.

noyan tayiji (*Ноён тайж*): Энэ тайжийн угсаа гарлыг бид хараахан тодруулж чадаагүй болно.

baba tayiji (*Баба тайж*): Халхын Сэцэн хан Шолойн хөвгүүдийн нэр, зэрэг цолны талаарх дээр дурьдсан сурвалжийн мэдээнд үндэслэвэл “Модон барс жилийн намрын цааз”-д нэр дурьдагдсан Баба тайж бол Сэцэн ханы ор залгамжилсан дөтгөөр хөвгүүн мөн хэмээн таамаглаж байна.

bing-tü tayiji (*Бинт тайж*): “Модон барс жилийн цааз”-д нэр бичигдсэн язгууртнууд нь ихэвчлэн Гэрсэнз жалайр хун тайжийн 3, 4-р хөвгүүний удмын ноёд байх тул энэхүү Бинт тайж нь Ангаахай мэргэн ноён гутгаар хөвгүүн мөн бололтой.

günbū-skiba tayiji (*Гүмбүскиб тайж*): Түүнийг Х.Пэрлээ “Засагт ханы төрлийн эрдэнэ хун тайжийн хөвгүүн Гомбожав тайж”¹ хэмээн тайлбарласан бол Фүтаки Хироши үүнд нэлээд эргэлзсэн² байдаг.

“Модон барс жилийн цааз”-д нэр бичигдсэн язгууртнууд нь ихэвчлэн Гэрсэнз жалайр хун тайжийн 3, 4-р хөвгүүний удмын ноёд байх тул gUnbU-skiba tayiji нь Засагт хан аймгийн ноён байх магадлал тун бага юм.

XVII зууны Халхын ноёдын угсаа залгамжлал, нэр цол болон цаазад бичигдсэн ноёдын нэрсийн дэс дараа зэргийг бодвол энэхүү gUnbU-skiba tayiji нь Рахул далай ноёны дэд хөвгүүн bumbaskib tayiji болов уу хэмээн таамаглаж байна. Тэрбээр Эеэр засагчийн 10-р /1653/ оны хаврын дунд сард тайж Гомбо (gümbü), Жамц (jamᠴu), Бумбаски (bumbaski) нарын хамт харъяат ардыг аван Манжид дагаар оров³. Эеэр засагч хаан энэ явдалд ихэд талархан хурим хуримлан, хишиг хүртээж Бунтар цөхүрийг Засгийн дархан чин ван, тайж Гомбо-ийг Төрийн зоригт жүн ван⁴, Жамцыг Улсын түшээ гүн⁵, Бумбаскибыг Хошууы тайж⁶ болгожээ.

Рахули далай ноёны ахмад хөвгүүд урван очсоноос хойш 3 жилийн дараа буюу Эеэр засагчийн арван гуравдугаар /1656/ оны 8 сарын шинийн 1-нд Манжийн Эеэр засагч хаанаас засгийн дархан чин ван Бунтар, төрийн зоригт чин ван Гомбо, улсын түшээ гүн Жамц, хошууны тайж Бумбаски нарт нэгэн адилаар “үнэн сэтгэлээр дагаж улс гүрэнд түшиг тулга болсон олон жилийн гавьяаг тоочин тэмдэглэж” хишиг соёрхолын зарлиг буулган, хойшид их төрд үнэнчээр зүтгэн

¹ Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, 129

² 二木博史著「訳注白樺法典(III)」、『モンゴル研究』第14期、1983年、23

³ mongyol dangsa ebkemel-ün emkidkel. dörbedüger emkidkel. 2003, 29-31

⁴ mongyul dangsa ebkemel-ün emkidkel. dörbedüger emkidkel. 2003, 22-24

⁵ mongyol dangsa ebkemel-ün emkidkel. dörbedüger emkidkel. 2003, 26-28

⁶ mongyol dangsa ebkemel-ün emkidkel. dörbedüger emkidkel. 2003, 29-31

явбаас “үеийн үед жаргаж, сайн нэрийг үүрд алдаршуулваас, мөнхүү маш үлэмж болох” хэмээн ухуулсан байдаг¹.

ĉembüim tayiji (Цэмбүт тайж): Х.Пэрлээ “Жодба сэцэн ноёны зургадугаар хөвгүүн Цэмбүл тайж мөн бололтой”² гэжээ.

Өнөөгийн судалгааны түвшинд “Халхын үйсэн цааз”-ыг хэлэлцэн тогтоосон язгууртнуудын угсаа гарвалын талаарх асуудал судлаачдын дунд харилцан санал зөрүүтэй байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд шинээр судалгааны эргэлтэнд орж буй архивын баримт болон түүхэн эх сурвалж зэрэг эх хэрэглэгдэхүүнд тулгуурлах цаашид нарийвчлан тодруулах бололцоотой нь харагдаж байна.

Дүгнэлт

“Халхын үйсэн цааз”-д цааз хэлэлцэгч язгууртан ноёд, тайж нарыг тэмдэглэхдээ тэдний угсаа язгуур, насны эрэмбэ дараагаар бичсэн зүйл ажиглагдаж байгаагаас үзэхэд энэ нь тухайн цагийн бичгийн тогтсон ёс бололтой.

“Модон барс жилийн намрын цааз”-ыг хэлэлцэн тогтоосон язгууртны нэр, цол, угсаа язгуурыг судлан үзэхэд тэдгээр нь Гэрсэнз жалайр хун тайжийн 3, 4-р хөвгүүний удмын ноёд ажээ. Үүнээс харахад Халхын долоон хошууны ноёд нийлэн их цааз хэлэлцэхээс гадна нэгэн удмын язгууртан ноёд тусгайлан цааз хэлэлцэж байжээ.

“Модон барс жилийн намрын цааз”-д нэр бичигдсэн язгууртнууд нь үеийн хувьд төрлийн тэргүүлэх ноёд, тэдний хөвгүүд, залгамжлагч гэсэн гурван бүлэгт хуваагдаж байна. Үүнд,

I. 2-оос 5 дугаарт бичигдсэн ноёд /нэг үе/

II. 6, 8, 9, 10, 13, 14, 15 дугаарт бичигдсэн ноёд /нэг үе/

III. 1, 19, 21, 22, 23 дугаарт бичигдсэн ноёд

тус тус нэг үеийн язгууртан ноёд ажээ.

Халхын үйсэн цаазад бичигдсэн язгууртны нэр, цол болон нэрсийн дэс дараалал нь Монгол ноёдын удам угсааг тодруулах гол баримжаа болж байна. Үйсэн цаазад ноёд, тайж нарыг нэрээр, цолоор, эсвэл нэр, цолыг хамтатган бичсэн гурван янзын бичлэг байгаа нь монгол хууль цаазын уламжлалын нэгэн онцлог ажээ.

¹ mongyol dangsa ebkemel-ün emkidkel. tabduyar emkidkel, 11-14, 30-33, 56-59, 59-62

² Монгол ба Төв Азийн орнуудын соёл түүхэнд холбогдох хоёр ховор сурвалж бичиг, 129

Abstract: The information by the “Law on the birch bark” is one of the basic sources to study Mongolian aristocrats’ genesis from the XVI century to the XVII century. In the article the genesis of the aristocrats who took part in the consideration of the “Law considered in the autumn, year of tiger” (1614) clarified and it was made conclusion that they were the aristocrats who came from the third and fourth sons of Gersenz jalair prince.

Модон барс жилийн намрын цаазын латин үсгийн галиг
modon bars jil-un namur-un čayaža
(1614 on)¹

043(b) /ö50/

- 1 oom suvasti siddam:: modon bars jil-un namur-un ečüs
- 2 sara-yin nigen sinede² altaγad-un γool³ deger-e: tüsiye=
- 3 tü qaγan: күнделен čö<<ge>>kür noyan: dayičing qung tayiji: dalai
- 4 sečen qung tayiji: čoγ-tu qung tayiji: sečen tayiji:
- 5 čaγan tayiji: erdeni tayiji: turqal tayiji: loyaγ tayiji:
- 6 nom-či tayiji: erke tayiji: mačari tayiji: labari tayiji: čabari
- 7 tayiji: qolači tayiji: bayatur tayiji: joriγ-tu
- 8 tayiji: čolom tayiji: no[...]n tayiji: baba tayiji:

044(a) /a50/

- 1 bing-tu tayiji: günbү-skiba tayiji: čembүm tayiji:
- 2 eden бүгүде noyad-i čayaža nigdebe: noyad
- 3 biy-e-ben alalčabasу qar-a biy-e-yi-ni kögejү
- 4 orkiy-a: qamuγ ulusi-i abču qubayaγ-a: qaγas-i
- 5 -ni alayuluγči⁴ noyan-tu öggүy-e: noyan töröl-iyen
- 6 abubasu ter-e abuči-yi-ni qaγačaγuluγad jaγun ger
- 7 күмүн abqu bolba: jaγun күмүн ügei bolbasu

041 (b) /ö51/

- 1 qaγaslaqu bolba: noyad süyitү-iyen abulčaquла ter-e süyitү-yi
- 2 <iyen> -ni qaγačaγuluγad: arban ger күмүн mingγan anju abqu
- 3 bolba: kedүн güyigsen күмүн kögegsen aduγusun noyad görilүji
- 4 ese ögbesү yeke čayaža-yin keb-iyer elči ilegeji бүгүдеger
- 5 abču öggүy-e: noyad tabunung-uud-tu abaqai deger-e
- 6 abaqai ögbesү urida abaqai-yi injitei-ni ečige-ni abqu
- 7 bolba: ter-e abaqai-tu inje buu⁵ ög: ögbesү jaγun
- 8 aduγu arban temege abqu bolba: tabunung-uud-tu doloγ[a]n
- 9 qosiyun-i noyad abaqai ögbesү qoyar abaqai-yi qaγačaγul=

042(a) /a51/

- 1 ju abqu bolba: tegүsbe:: mangglam::

¹ Цааз хэлэлцсэн оныг дахин нягтлах шаардлагтай.

² modon bars jil-un namur-un ečüs sara-yin nigen sinede (модон барс жилийн намрын эцэс сарын нэгэн шинэд).

³ Altaγad-un γool (Алтагадын гол).

⁴ Энэ үгийг Х.Пэрлээ alayulaγči гэж галиглажээ.

⁵ Энэ үгийг Х.Пэрлээ böү гэж галиглажээ

Модон барс жилийн намрын цаазын
эх бичгийн гэрэл зураг







